

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 11.020.01

Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа	MNS 5095:2017
The structure and activity of General hospital	MNS 5095:2013-ын оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор батлав.

Стандарт нь 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын норматив шаардлагыг заавал мөрдөнө.

1 Зорилго

Нэгдсэн эмнэлгээс үйлчлүүлэгчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулахад оршино.

2 Хамрах ба хэрэглэх хүрээ

2.1 Үйлчлүүлэгчид үндсэн мэргэшлийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллагыг хамарна.

2.2 Энэ стандартын 2.1-д заасан эрүүл мэндийн байгууллага стандартын норматив шаардлагыг ханган, тусламж, үйлчилгээг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгох, магадлан итгэмжлэхэд хэрэглэнэ.

3 Норматив ишлэл

Энэ стандартад иш татаж хэрэглэсэн дараахь баримт бичигт өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн албан ёсны эх баримт бичгийг баримтална.

- 3.1 БНБД 30.01.04. Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм,
- 3.2 БНБД 31-03-03, “Олон нийт иргэний барилгын норм ба дүрэм”
- 3.3 БД 31-115-12 “Эмнэлгийн барилгын дүрэм ба зөвлөмж”,
- 3.4 БД 43-101-03*/12 “Цахилгаан байгууламжийн дүрэм. Бүлэг 1,6 “Газардуулга ба цахилгааны аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ”
- 3.5 MNS 5973:2009 “Барилга байгууламжид ногоон байгууламжийн ойртох зай, хэмжээ түвшин”
- 3.6 MNS 6056:2009 “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, үндсэн шаардлага”
- 3.7 MNS 6056:2009 “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар”
- 3.8 MNS 4990:2015 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага”
- 3.9 MNSOSHAS18001:2012 “Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо-шаардлага”
- 3.10 MNS 12,013:1991 “Ажлын байрны бичил цаг уурын эрүүл ахуйн хэмжээ”
- 3.11 MNS 900:2010 “Ундны усны эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт”

MNS 5095:2017

- 3.12** MNS 6392:2013 “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага”
- 3.13** MNS 5027:2001 “Дэлгэц бүхий тоног төхөөрөмжтэй ажиллах эрүүл ахуй. Эргономикийн ерөнхий шаардлага”
- 3.14** MNS 6458:2014 “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага”.
- 3.15** MNS CAC/RCP 39:2011 Нийтээр нь үйлчлэх хоол, үйлдвэрлэл үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал
- 3.16** MNS 4946:2005 Хоолны газрын ангилал, зэрэглэл, шаардлага
- 3.17** MNS 12,05,051:1991 “Ажлын байрны агаарт байж болох цацраг идэвхт бодисын хэмжээ”
- 3.18** MNS 12.097:1991, MNS 12.098-91, MNS 12.101-091 “Ажлын байрны хүчдэлийн түвшин”
- 3.19** MNS 5146:2002 “Цахилгааны аюулгүй ажиллагаа. Хамгаалах газардуулга тэлэлт”
- 3.20** MNS ГОСТ 5583 “Техникийн болон эмнэлгийн зориулалтай, хийн байдалтай хүчилтөрөгч. Техникийн шаардлага”
- 3.21** MNS 4244:1994 “Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага”
- 3.22** MNS 5566:2005 “Аж ахуйн нэгж, байгууллага, барилга, байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм”
- 3.23** MNS 6881:2010 “Амаржих газрын бүтэц, үйл ажиллагаа”
- 3.24** MNS ISO 13485-98 “Эмнэлгийн хэрэгслүүд- ИСО 9001 стандартыг хэрэглэхэд тавигдах онцлог шаардлагууд
- 3.25** MNS 5391:2010 “Рентген оношилгооны төхөөрөмжийн ажиллагаанд чанарын хяналтын хэмжилт хийх арга. Техникийн шаардлага”
- 3.26** “Рентген кабинет ионжуулагч туяа үүсгэгч аппарат төхөөрөмжийг ашиглах, суурилуулах болон рентген шинжилгээ хийх үед мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм”
- 3.27** MNS ISO 15189:2015 “Эрүүл мэндийн лаборатори-чанар болон чадавхид тавих шаардлага”
- 3.28** MNS 6616:2016 “Эмнэлзүйн лабораторийн аюулгүй ажиллагаа”
- 3.29** MNS 4621:2008 “Эрүүл мэндийн технологи. Эмчилгээ, оношилгооны түгээмэл үйлдлүүд”
- 3.30** MNS 5991:2009 “Зонхилон тохиолдох өвчний үеийн хоол эмчилгээ”
- 3.31** MNS 5095:2001 “Яаралтай тусламжийн биксэнд байх эм, эмнэлгийн хэрэгсэл”
- 3.32** MNS 5376:2014 “Эмийн жорын маягт, жор бичилт”
- 3.33** MNS 5260:2015 Эрүүл мэндийн технологи. “Эмийн санд тавих нийтлэг шаардлага”
- 3.34** MNS 5530:2014 Эрүүл мэндийн технологи.”Эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтэд тавих ерөнхий шаардлага”
- 3.35** MNS 5766:2007 “Байгалийн голомтот халдварт өвчний халдвартай ба сэжигтэй материалыг халдваргүйтгэх техникийн шаардлага”
- 3.36** MNS 5377:2004 “Цогцсын шинжилгээний арга, эмгэг судлалын оношийн бүтэц”

4 Нэр томъёо ба тодорхойлолт

4.1

Нэгдсэн эмнэлэг (цаашид “эмнэлэг” гэх)

оноосон нэртэй, улсын бүртгэлд бүртгүүлсэн, тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд байх бөгөөд хүн амд 7-гоос доошгүй үндсэн мэргэшлээр эмнэлгийн

лавлагаа тусламж, үйлчилгээг амбулатороор болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх эрүүл мэндийн байгууллага байна.

4.2

Үйлчлүүлэгч

тухайн эмнэлгээс тусламж, үйлчилгээ авч байгаа иргэн, түүний асран хамгаалагчийг хамааруулж ойлгоно.

4.3

Үйлчилгээ үзүүлэгч

эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд оролцож байгаа үндсэн болон гэрээт бүх ажилтныг хамааруулж ойлгоно.

5 Эмнэлгийн нийтлэг үйл ажиллагаа

5.1 Эмнэлэг нь холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн батлагдсан дүрэм, бүтэцтэй байна. Эмнэлгийн бүтэц нь алба, тасаг, нэгж байна.

5.2 Эмнэлэг нь салбарын болон орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдсан төлөвлөгөөтэй ажиллана.

5.3 Санхүү, төсвийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартыг мөрдөж ажиллана.

5.4 Эмнэлэг нь тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бүрдүүлэн, чанар, аюулгүй байдлыг ханган ажиллана.

5.5 Эрүүл мэндийн технологи, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн заавар, удирдамжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, чанар сайжруулах арга хэрэгслийг нэвтрүүлэн, тогтмолжуулан ажиллана.

5.6 Байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлнэ.

5.7 Эмнэлэг нь алдаа гарахаас урьдчилан сэргийлэх, алдааг илрүүлэх, гарсан алдааг бүртгэх, мэдээлэх, засаж залруулах арга хэмжээг тухай бүрт авч ажиллана.

5.8 Үйлчилгээ үзүүлэгч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч, дүгнэлт хийн, чанар, аюулгүй байдлыг сайжруулахад анхаарч ажиллана.

5.9 Эмнэлэг нь эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, хэм хэмжээг баримтлан, ёс зүй, харилцаа хандлагын зөрчлөөс сэргийлж ажиллана.

6 Хүний нөөцийн үйл ажиллагаа

6.1 Мэргэшсэн, чадварлаг, өндөр бүтээмжтэй багийг бүрдүүлэх хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг эмнэлгийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан хэрэгжүүлнэ. Хөтөлбөр нь энэхүү стандартын 6.2-6.11-т дурдсан хүний нөөцийн удирдлагын үндсэн чиг үүргийг бүрэн хамарч, 3 жил тутамд шинэчлэгдэн, ажилтанд ил тод байна.

6.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай, чанартай үзүүлэхэд шаардлагатай эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтэн, ажилтны

хэрэгцээг тооцож, сул орон тоог нөхөх, ажилтныг мэргэжил, албан тушаалын хувьд ахиулах төлөвлөлт (карьер)-ийг ойрын болон дунд хугацаагаар хийж, эмнэлгийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулан хэрэгжүүлнэ. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан үлгэрчилсэн загварын дагуу ажлын байрны тодорхойлолтыг байгууллагын бүх албан тушаал, мэргэжлээр гаргаж, өөрчлөлт ороогүй тохиолдолд 3 жил тутамд, өөрчлөлт орсон тухай бүрд шинэчлэн, шинээр тасаг, нэгж, ажлын байр үүссэн тухай бүрд шинээр боловсруулан баталгаажуулна.

6.3 Хүний нөөцийг бүрдүүлэхэд тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан нэр дэвшигчийг байгууллагын дотроос болон гаднаас ил тод сонгон шалгаруулж ажилд авна. Эмнэлгийн үйл ажиллагааны онцлог, хэрэгцээ, шаардлагатай уялдуулан үндсэн орон тоогоор ажиллах шаардлагагүй зарим ажлын байранд тухайн ажлын байрны шаардлагыг хангасан нэр дэвшигчийг сонгон шалгаруулж гэрээгээр ажиллуулж болно.

6.4 Шинэ ажилтанд байгууллагын үйл ажиллагаатай танилцуулах болон мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх сургалтыг зохион байгуулна. Ажилтан бүрийн ур чадвар, туршлагыг үнэлж, тэднийг сургах, хөгжүүлэх төлөвлөгөөг жил бүр хэрэгжүүлэхээс гадна ажилтан бүр ойрын болон дунд хугацаанд өөрийгөө хөгжүүлэх ажлын төлөвлөгөөтэй байна.

6.5 Ажлын байрны тодорхойлолтод үндэслэн ажилтан болон ажил олгогч хамтран ажилтныг жил бүр үнэлэх бөгөөд үнэлгээний дүнг бичгээр баталгаажуулан хувийн хэрэгт нь хадгална. Ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг харгалзан ажилтныг шагнаж урамшуулах, цалин нэмэх, албан тушаал дэвшүүлэх ажлыг ил тод зохион байгуулж, алдааг арилгах, сэргийлэх, ололт амжилтыг нийтийн хүртээл болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.6 Ажилтны нийгмийн хамгааллыг дэмжсэн арга хэмжээг хэрэгжүүлэх бөгөөд ажилтан бүрт адил, тэгш байна.

6.7 Эмнэлэг нь ажилтанд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдүүлж, эрүүл, аюулгүй ажлын орчин бүрдүүлэх, ажлын байран дахь осол, гэмтлээс сэргийлэх, ажлын байрны стрессийг бууруулах, аюулгүй ажиллагааны соёлыг дэмжсэн арга хэмжээг хэрэгжүүлж үр дүнг тооцно.

6.8 Ажилтныг өөр ажил, албан тушаалд шилжүүлэх, сэлгэх, ажлаас чөлөөлөх, хөдөлмөрийн гэрээ цуцлах, хариуцлага хүлээлгэх, нөхөн төлбөр олгох, ажил амралтын цагийн зохицуулалт, ажилтан хоорондын болон удирдах албан тушаалтан, ажилтан хоорондын харилцаа, ажилтны санал, гомдол шийдвэрлэлт зэрэг хөдөлмөрийн харилцаатай холбоотой бусад асуудлыг холбогдох хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэж, шийдвэрийг баталгаажуулан ил тод мэдээлнэ.

6.9 Хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааны талаарх бичмэл тайлангаас гадна төрийн захиргааны төв байгууллагаас баталсан маягтын дагуу тоон мэдээлэл бүхий тайланг жил бүр гаргаж байгууллагын ажилтан болон холбогдох эрх бүхий байгууллагад ил тод тайлагнана.

6.10 Ажилтан бүрт хувийн хэрэг хөтлөх бөгөөд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрсөн хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой мэдээний санг хөтлөн, тогтмол баяжилт хийнэ.

6.11 Хүний нөөцийн удирдлагатай холбоотой бүх үйл ажиллагаа, холбогдох баримт бичигт тодорхой давтамжтай дүн шинжилгээ хийж, тасралтгүй боловсронгуй болгон сайжруулна.

7 Эмнэлгийн бүртгэл, мэдээллийн үйл ажиллагаа

7.1 Эмнэлэг нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээлэл, тайланг холбогдох хууль, дүрэм, журам, тушаалын дагуу цаг хугацаанд нь шуурхай, үнэн зөв, ил тод, тогтмол мэдээлдэг байна.

7.2 Мэдээ тайланг цаасан болон электрон хэлбэрээр холбогдох хууль, дүрэм, журмын дагуу архивлан хадгалсан байна.

7.3 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрсөн статистик, бүртгэл, тайлагналтын мэдээллийн болон бусад зориулалтын программ хангамжтай байх бөгөөд шаардлагатай мэдээний санг үүсгэн баяжилтыг тогтмол хийж хэвшсэн байна.

7.4 Эмнэлэг нь мэдээллийн дотоод сүлжээтэй байх ба сүлжээний аюулгүй байдал, нууцлалыг хангасан байна.

7.5 Хувь хүний мэдээллийн нууцлалыг хуулийн дагуу хамгаалсан байна.

8 Хяналт-шинжилгээ, үнэлгээ

8.1 Эмнэлэг нь энэхүү стандартын хэрэгжилтэд дотоодын хяналт-шинжилгээ, үнэлгээг багаар тогтмол хийж, гарсан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана.

8.2 Тусламж, үйлчилгээний хүртээмж, чанар, аюулгүй байдал болон холбогдох тушаал шийдвэр, албан даалгавар, стандарт, эмнэл зүйн заавар, удирдамж, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцно.

8.3 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, мэдлэг ур чадварт үнэлгээ өгч, урамшуулал, хариуцлагын тогтолцоог нэвтрүүлнэ.

8.4 Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн эрэлт, хэрэгцээ, өргөдөл, гомдлын мөрөөр хяналт хийнэ.

8.5 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын үр дүнгийн тайланг холбогдох бүтцийн нэгжид хэлэлцүүлж, хамт олон, холбогдох байгууллагад нээлттэй мэдээлнэ.

9 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах үйл ажиллагаа

Тусламж, үйлчилгээний тасралтгүй байдалд эмнэлгийн ачааллыг зохицуулах, үйлчилгээний орчин, үйлчлүүлэгчтэй харилцах үйл ажиллагаа, үйлчлүүлэгчийг хүлээн авах, үйлчлүүлэгчийг шилжүүлэх, үйлчлүүлэгчийг эмнэлгээс гарах үйл ажиллагааг хамааруулна.

9.1 Эмнэлгийн ачааллыг зохицуулах үйл ажиллагаа

9.1.1 Тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг зохицуулах өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон журамтай байна.

9.1.2 Эрх бүхий байгуулагаас баталсан орны дээд хязгаарт багтаан өөрийн үзүүлэх эмнэлгийн ачаалал, байгууллагын хүчин чадалд нийцүүлэн өдрийн болон хэвтүүлэн эмчлэх орны тоог тооцож, зохион байгуулан ажиллана.

9.1.3 Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, хөнгөвчлөх, тусгаарлах орыг холбогдох тушаал, шийдвэрийн дагуу өвчний ачаалал, эмнэлгийн хүчин чадалтай уялдуулан зохицуулсан байна.

9.1.4 Яаралтай тусламж, хүлээн авах, амбулаторийн кабинетын ажиллах үйл ажиллагаа, урсгалыг үндсэн мэргэшлийн чиглэл, онцлог, өвчний ачаалал, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулсан байна.

9.1.5 Эмнэлгийн орны ачаалал, ашиглалтыг зохицуулах зорилгоор тасаг хооронд орны шилжүүлэг хийнэ.

9.1.6 Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал, гэнэтийн осол, байгалийн гамшиг зэрэг онцгой тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу орны зохицуулалтыг хийнэ.

9.2 Үйлчилгээний орчин, үйлчлүүлэгчтэй харилцах үйл ажиллагаа

9.2.1 Эмнэлэг нь үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн сэтгэлд нийцсэн “ээлтэй” орчныг бүрдүүлж ажиллана.

9.2.2 Тусламж, үйлчилгээний лавлагаа мэдээллийг шуурхай хүргэх, санал, хүсэлтийг хүлээн авах, урсгалыг зохицуулах үүрэг бүхий хөтөч, туслагч ажиллуулна.

9.2.3 Үйлчлүүлэгчийн дараалал, цаг товлолтыг цахим болон автомат бүртгэлээр зохицуулна.

9.2.4 Амбулаторийн хүлээлгийн хэсэгт “Үйлчлүүлэгч-Үйлчилгээ үзүүлэгч”-ийн эрх, үүрэг, үзүүлэх тусламж, үйлчилгээний багц, төлбөр, хөнгөлөлтийн талаарх мэдээлэл, эмнэлгийн зохион байгуулалт, үйлчилгээний талаарх тэмдэг, тэмдэглэгээг ил тод ойлгомжтойгоор байршуулах ба нэг цэгийн үйлчилгээ (сандал, даралт, жин хэмжих хэрэгсэл, сургалт, сурталчилгааны материал, хэвлэл)-тэй байна.

9.2.5 Үйлчлүүлэгчийн талаархи мэдээллийг утас болон амаар авсан эмнэлгийн мэргэжилтэн нь мэдээллийг тэмдэглэн авч холбогдох эмч, мэргэжилтэнд заавал бичгээр мэдээлж баталгаажуулна.

9.2.6 Үйлчлүүлэгчийн санал, хүсэлт өгөх, мэдээлэл, зөвлөгөө авах боломжийг бүрдүүлсэн байна.

9.2.7 Тасаг, нэгжийн хүлээлгийн хэсэгт тухайн нэгжийн бүтэц, үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлэгчийн талаарх товч мэдээллийг байрлуулж, эрүүл мэндийн мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

9.2.8 Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгч, хүүхэд, өндөр настантай харилцах, үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

9.3 Үйлчлүүлэгчийг хүлээн авах

9.3.1 Үзлэг, үйл онош, лабораторийн шинжилгээний дугаар, хүлээгдлийн талаарх мэдээллийг ил тод байршуулна.

9.3.2 Үйлчлүүлэгчийг хүлээн авах анхан шатны маягтын дагуу бүртгэнэ.

9.3.3 Үйлчлүүлэгчийг хүлээн авсан эмч урьдчилсан оношийг тавин шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэн, эмчлэгч эмчид хүлээлгэн өгнө.

9.3.4 Яаралтай журмаар ирсэн үйлчлүүлэгч бүрийг хүлээн авч, эрэмбэлэн ангилалт хийн, дараалал, цаг товлолт харгалзахгүйгээр холбогдох журмын дагуу үйлчилгээг үзүүлнэ.

9.3.5 Яаралтай тусламжаас бусад тохиолдолд үйлчлүүлэгчийг оношилгоо, эмчилгээний хэрэгцээ болон эмнэлэг өөрийн үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд хүлээн авах эсэхийг шийдвэрлэж, үйлчлүүлэгчид шийдвэрийг тодорхой тайлбарлаж, бичгээр өгнө.

9.3.6 Үйлчлүүлэгчийг хүлээн авах, хяналтанд бүртгэх, бүртгэлээс хасах үйл явц журмын дагуу нарийвчилсан бүртгэлтэй, ил тод, нээлттэй байна.

9.3.7 Үйлчилгээ үзүүлэгч үзүүлж буй, үзүүлэх гэж буй тусламж, үйлчилгээний талаар үйлчлүүлэгчид үнэн зөв, ойлгомжтой тайлбарлах бүрэн мэдээлэлтэй байна.

9.3.8 Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн хэрэгцээ, эмнэлгийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл байгаа эсэхийг 7 хоног бүр судлан тогтоож, шалтгаан, нөхцөлийг тодорхойлон, хүлээгдлийг бууруулах арга хэмжээ авч ажиллана.

9.4 Үйлчлүүлэгчийг шилжүүлэх

9.4.1 Эрүүл мэндийн байгууллага, тасаг хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, эмнэлгээс гарсны дараа үйлчлүүлэгчтэй эргэж холбоо барих үйл ажиллагааг холбогдох тушаал, шийдвэрийн дагуу байгууллагын дотоод журмаар тодорхой зохицуулсан байна.

9.4.2 Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд эмнэлгийн ээлж солигдох, тасаг хооронд шилжүүлэх үед үйлчлүүлэгчийг биечлэн заавал хүлээлцэнэ.

9.4.3 Үйлчлүүлэгчийг хүлээж авсанаас эхлэн гэрт нь гаргах буюу шилжүүлэх хүртэлх тусламж, үйлчилгээний үйл явц ил тод, шуурхай, ойлгомжтой байна.

9.4.4 Эмнэлэг нь эмнэлзүйн заавар, журамд үндэслэн үйлчлүүлэгчийг эмнэлэгт хэвтүүлэх, шилжүүлэх шалгуур гаргаж, мөрдүүлнэ.

9.4.5 Үйлчлүүлэгчийг шилжүүлэхдээ биеийн байдал, оношилгоо, эмчилгээ, хийгдсэн шинжилгээ түүний өөрчлөлтийг тэмдэглэсэн баримт бичгийн хамт шилжүүлнэ.

9.4.6 Шилжүүлэх баримт бичигт шилжүүлэх шалтгаан, шилжүүлэх үеийн үйлчлүүлэгчийн биеийн байдал, шилжүүлэх явцад биеийн байдалд өөрчлөлт орсон эсэх болон үйлчлүүлэгчийг шилжүүлэхтэй холбоотой эрхзүйн заалт, тусгай нөхцөл байгаа эсэхийг баримтжуулсан байна.

9.5 Үйлчлүүлэгчийг эмнэлгээс гаргах

9.5.1 Үйлчлүүлэгчийг эмнэлгээс гаргахдаа цаашид баримтлах дэглэм, заавар, зөвлөмж, үргэлжлүүлэн авах тусламж, үйлчилгээний талаарх мэдээлэл, эмнэлгээс гаргах үеийн дүгнэлтийг иргэний эрүүл мэндийн дэвтэрт заавал тэмдэглэнэ.

9.5.2 Үйлчлүүлэгчийг эмнэлгээс гарах үеийн дүгнэлтийг монгол хэлээр бичих ба хуулбарыг өвчний түүхэнд хавсаргасан байна.

9.5.3 Үйлчлүүлэгчийг эмнэлгээс гарахад нь хийгдсэн шинжилгээ, эмчилгээ, цаашид хийгдвэл зохих тусламж, үйлчилгээний талаар үйлчлүүлэгчид тайлбарлан, зөвлөгөө өгсөн байна.

9.5.4 Эмчлүүлэгчийг гаргахдаа тээвэрлэлтийг хэрэгцээг тодорхойлж, аюулгүй байдлыг хангасан нөхцөл бүхий тээврийн хэрэгслээр гаргана.

9.5.5 Тээврийн зардал, төлбөр, аюулгүй байдал, гэрээт үйлчилгээний асуудлыг холбогдох хууль, тогтоомжтой нийцүүлэн шийдвэрлэнэ.

10 Сургалт, бусад эрүүл мэндийн байгууллагаас мэргэжил арга зүйн дэмжлэг авах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагаа

10.1 Сургалт

10.1.1 Эмнэлэг тасралтгүй суралцагч байгууллага байж, бусад байгууллагатай харилцан туршлагаас суралцах, эрүүл мэндийн ажилтныг сургалтанд хамруулах ажлыг зохион байгуулна.

10.1.2 Эмнэлэг нь сургалт явуулах, суралцагчдад дадлага хийх нөхцөл, бололцоог бүрдүүлсэн байна.

10.1.3 Эмнэлзүйн ба эмгэг судлалын хамтарсан хурлыг эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, дүгнэлт зөвлөмж гаргах зорилгоор тогтмол зохион байгуулна.

10.1.4 Өндөр хөгжилтэй орны ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагад өөрийн ажилтанг сургах, мэргэшүүлэх, дэвшилтэт технологи нэвтрүүлэхэд мэргэжилтэн урьж хамтран ажиллана.

10.2 Бусад эрүүл мэндийн байгууллагатай хамтарч ажиллах, мэргэжил арга зүйн дэмжлэг авах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагаа

10.2.1 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагын баталсан журмын дагуу холбогдох эрүүл мэндийн байгууллагад лавлагаа, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

10.2.2 Эмнэлэг нь холбогдох шийдвэрийн дагуу, тусламж, үйлчилгээнд тулгамдаж буй асуудлыг статистик тоон мэдээлэлд үндэслэн харилцан санал солилцож, холбогдох эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр ханган, лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

10.2.3 Эмнэлэг нь төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, нэгдсэн эмнэлгээс лавлагаа мэргэжил арга зүйн дэмжлэг авч хамтран ажиллана.

10.2.4 Эмнэлэг нь эмнэлгийн ажилтанг сургах, ур чадварыг дээшлүүлэхэд бусад байгууллагатай хамтран ажиллана.

10.2.5 Эмнэлэг нь цахим сүлжээ ашиглан зайн сургалт, зөвлөгөө, мэргэжил арга зүйн дэмжлэг авах, үзүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

11 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

11.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний бүтэц, үйл ажиллагаа

11.1.1 Оношилгоо, эмчилгээ

11.1.2 Сувилахуй

11.1.3 Сэргээн засах

11.1.4 Яаралтай тусламж

11.1.5 Эрчимт эмчилгээ

11.1.6 Гамшгийн үеийн тусламж, үйлчилгээ

11.1.7 Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, цус сэлбэлт судлал

11.1.8 Эмгэг судлал

11.1.9 Эмзүйн тусламж, үйлчилгээ

11.1.10 Түргэн тусламж

11.1.11 Уламжлалт анагаах ухаан

11.1.12 Хөнгөвчлөх

11.1.13 Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ

11.1.13.1 Дотрын анагаах

11.1.13.2 Мэдрэл

11.1.13.3 Хүүхэд

11.1.13.4 Мэс засал

11.1.13.5 Гэмтэл согог

11.1.13.6 Эх барих, эмэгтэйчүүд, нөхөн үржихүй

11.1.13.7 Халдварт өвчин ба зооноз

- 11.1.13.8 Сүрьеэ
- 11.1.13.9 Нүүр ам судлал
- 11.1.13.10 Насжилт, настны эмгэг судлал
- 11.1.13.11 Өсвөр үеийн эрүүл мэнд
- 11.1.13.12 Сэтгэц
- 11.1.13.13 Арьс, харшил
- 11.1.13.14 Нүд судлал
- 11.1.13.15 Чих, хамар хоолой
- 11.1.13.16 Нүүр ам судлал
- 11.1.13.17 Хавдар
- 11.1.13.18 Бусад

11.2 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

Тандалт судалгаа, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

11.3 Эмнэлгийн дэмжих үйлчилгээ

- 11.3.1 Нийгэм-сэтгэлзүй, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ
- 11.3.2 Хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн үйлчилгээ
- 11.3.3 Эмнэлгийн тоног төхөөрөмж, инженерийн байгууламж
- 11.3.4 Санхүү, аж ахуй, хангамж
- 11.3.5 Түргэн тусламжийн автомашины парк
- 11.3.6 Мэдээлэл технологи, харилцаа холбоо
- 11.3.7 Төвлөрсөн ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ
- 11.3.8 Угаалга, цэвэрлэгээ
- 11.3.9 Эмнэлгийн дохиолол, хамгаалал
- 11.3.10 Эмнэлгийн хог хаягдал

12 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ

12.1 Оношилгоо, эмчилгээ

12.1.1 Үндсэн мэргэшлийн тусламж, үйлчилгээний чиглэл, онцлогоос хамаарч эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Эмнэлэг нь амбулатори, хэвтүүлэн эмчлэх, оношилгоо шинжилгээг цогц байдлаар үзүүлнэ.

12.1.2 Үйлчлүүлэгчид үзлэг, оношилгоо, эмчилгээг “Эрүүл мэндийн технологи. Эмчилгээ, оношилгооны түгээмэл үйлдлүүд” болон бусад батлагдсан стандарт технологи, эмнэлзүйн заавар, удирдамжийн дагуу үзүүлнэ.

12.1.3 Оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн зааварт заасан мэргэшсэн хүний нөөц, зориулалтын өрөө тасалгаа, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

12.1.4 Амбулаторийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн мэргэжилтний өдрийн ачааллыг жигд, тэнцвэртэй зохион байгуулж, үйлчлүүлэгч эмчээ сонгох боломжоор хангана.

12.1.5 Үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээ хийх бүрд холбогдох анхан шатны бүртгэлийн маягт, хяналтын хуудсыг хөтөлнө.

12.1.6 Үйлчлүүлэгчид оношилгоо, эмчилгээний үйлдэл, ажилбар, мэс засал хийхийн өмнө эмнэлгийн мэргэжилтэн өөрийгөө болон үзүүлэх гэж байгаа тусламж, үйлчилгээний талаар товч танилцуулж, холбогдох журмын дагуу зөвшөөрөл авсан байна.

12.1.7 Үйлчлүүлэгчийг зохих журмын дагуу хүлээн авсан эмч урьдчилсан оношийг тавин шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэн, эмчлэгч эмчид хүлээлгэн өгнө.

12.1.8 Эмнэлгийн жижүүр эмч нь үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээг ажлын бус цагаар бүрэн хариуцна.

12.1.9 Үйлчлүүлэгчийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээг өвчний түүх, иргэний эрүүл мэндийн дэвтэрт стандартын дагуу тодорхой тэмдэглэж, бүрэн хөтөлнө.

12.1.10 Яаралтай мэс засал, хавсарсан хүнд гэмтлийн тусламж, үйлчилгээг холбогдох дүрэм, журам, заавар, хөтчид заасан хугацаанд хийсэн байна.

12.1.11 Биеийн байдал хүнд байгаа үйлчлүүлэгчийг эмнэлзүйн заавар, удирдамж, хөтчийн дагуу хянаж, өвчний түүхэнд тэмдэглэсэн байна.

12.1.12 Мэс заслаар авагдсан зүйлсийг эд, эсийн шинжилгээнд заавал өгч, шинжилгээний хариуг өвчний түүхэнд хавсарган тэмдэглэж, үйлчлүүлэгчийг мэдээллээр хангана.

12.1.13 Шинэ болон дахин сэргэж байгаа халдвар, зоонозын халдварт өвчний тусламж, үйлчилгээ үзүүлэх эм тариа, ариутгах, халдваргүйжүүлэх бодис, сорьц зөөвөрлөх сав болон хамгаалах хувцас, хэрэгслийн нөөцтэй, бэлэн байдлыг хангасан байна.

12.1.14 Эмнэлэг нь үндсэн мэргэшлийн чиглэлээр шинэ дэвшилтэт арга хэрэгсэл, технологи нэвтрүүлж, үр дүнг тооцож ажиллана.

12.1.15 Оношилгоо, шинжилгээг лабораторийн оношилгооны техникийн шаардлага, оношлуурын аргын стандарт болон Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад стандарт, үйлдвэрлэгчээс заасан зааврын дагуу хийнэ.

12.1.16 Лаборатори нь клиник-хими, биохими, гематологи, дархлаа судлал, микробиологийн шинжилгээ, өөрийн тусламж, үйлчилгээний чиглэл, онцлогт хамаарах төрөлжсөн шинжилгээг хийнэ.

12.1.17 Лабораторийн эмнэлзүйн хими/биохими, гематологи, иммунологийн хэсэг нь заалны зохион байгуулалттай, байж болох ба энэ тохиолдолд заалны талбайг эдгээр хэсгийн талбайн нийлбэрээр тооцно.

12.1.18 Лабораторийн төрөлжсөн нарийн мэргэшлийн тусламж, үйлчилгээ болон зарим шаардлагатай шинжилгээг (генетик, молекул биологи гэх мэт) гэрээгээр гүйцэтгүүлж болох ба сорьцыг холбогдох журмын дагуу илгээж шинжлүүлнэ.

12.1.19 Микробиологийн хэсэг нь тусгаарлагдсан, С2 хавсралтад заагдсан шаардлагыг хангасан байна.

12.1.20 Молекул биологийн лаборатори шаардлагатай тохиолдолд В2 тоног төхөөрөмж, өрөө тасалгааны С2 хавсралтад заагдсан шаардлагыг хангасан байна.

12.1.21 Рентген, хэт авиа, уян дурангийн болон бусад өөрийн тусламж, үйлчилгээний чиглэл, онцлогт хамаарах төрөлжсөн оношилгоог хийнэ.

12.1.22 Дүрс оношилгоо, лабораторийн тоног төхөөрөмж нь эмнэлгийн мэдээллийн систем, зурган мэдээллийг хадгалах, дамжуулах системийн өгөгдөлтэй байна.

12.2 Сувилахуй тусламж, үйлчилгээ

12.2.1 Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах төлөвлөгөөтэй, хэрэгжилтийг хангаж ажиллана.

12.2.2 Сувилахуйн тусламж, үйлчилгээг дархлаажуулалт, уламжлалт анагаах ухааны бариа засал, сэргээн засах, мэдрэл, сэтгэц, мэдээгүйжүүлэг, мэс засал, эрчимт эмчилгээний, яаралтай, эмэгтэйчүүд, нярай, хүүхэд, эх барихуй, насанд хүргэгчдийн, хөнгөвчлөх, хавдрын, цус судлалын, нийгмийн эрүүл мэнд гэх мэт төрөлжсөн чиглэлээр үзүүлнэ.

12.2.3 Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн нь үйлчлүүлэгчид эрүүл мэндийн зөвлөгөө өгөх арга барил, түгээмэл (гардан) үйлдлийг технологийн дагуу хийх ур чадварыг бүрэн эзэмшсэн байна.

12.2.4 Эмнэлзүйн сувилахуйн тусламж, үйлчилгээг “Эрүүл мэндийн технологи. Эмчилгээ, оношилгооны түгээмэл үйлдлүүд” стандарт, эмнэлзүйн заавар, удирдамж, технологийн дарааллын дагуу бүрэн хийнэ.

12.2.5 Сувилахуйн ба эх барихуйн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт арга хэрэгсэл, үйлчилгээний соёлыг нэвтрүүлэхэд мэргэжил арга зүй, дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллана.

12.2.6 “Туслах сувилагч”-ийн үйл ажиллагааг аргазүйгээр хангаж, ажлын байран дах сургалтанд хамруулна.

12.3 Сэргээн засах тусламж, үйлчилгээ

12.3.1 Өвчин эмгэг, гэмтэл бэртэлийн улмаас бий болсон хүний бие махбод болон сэтгэцийн үйл ажиллагааны чадвар алдагдлыг оношлох, эмчлэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэхэд олон мэргэжилтний багийн үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, хүртээмж, үр дүнг тооцож ажиллана.

12.3.2 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд болон үйл ажиллагааны чадвар алдагдсан (хавсралтанд заасан) тусламж, үйлчилгээ үзүүлэх нэн шаардлагатай хэрэгсэл, төхөөрөмжөөр хангагдсан, хүний нөөцийг чадавхижуулсан байна.

12.3.3 Сэргээн засах тусламж, үйлчигээг хэл, хөдөлгөөн, хөдөлмөр заслын чиглэлээр үзүүлнэ.

12.3.4 Сэргээн засах тусламж, үйлчилгээг сэргээн засах эмчилгээний хяналтын хуудасыг хөтлөн, “Сэргээн засах эмчилгээний ерөнхий төлөвлөгөө”-ний дагуу гүйцэтгэнэ.

12.4 Яаралтай тусламж, үйлчилгээ

12.4.1 Яаралтай тусламж, үйлчилгээг тухайн чиглэлээр сургагдсан мэргэжлийн баг, бусад мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй хамтран гүйцэтгэнэ.

12.4.2 Яаралтай тусламж нь үйлчлүүлэгчийг эрэмбэлэн ялгах, яаралтай тусламж үзүүлэх, онош тодруулах-ажиглалт хийх, тусгаарлах, ариун цэврийн өрөөтэй байна.

12.4.3 Яаралтай тусламж нь бүртгэх, лавлагаа мэдээллийг өгөх боломжийг бүрдүүлсэн байна.

12.4.4 Тусгаарлах өрөөг эмнэлгийн хүчин чадал, үйл ажиллагааны онцлог, тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан зохион байгуулна.

12.4.5 Яаралтай тусламж, үйлчилгээг 24 цагаар тасралтгүй үзүүлэхээр зохион байгуулагдаж, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, техник тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

12.4.6 Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал, гамшиг үүссэн үед авах арга хэмжээний төлөвлөгөө, дуудагдаж ажиллах эмч, мэргэжилтний хаяг, утасны бүртгэлтэй байна.

12.4.7 Яаралтай тусламжийн нэгж нь үйлчлүүлэгч ба түүний ар гэрийнхнийг шаардлагатай мэдээллээр хангана.

12.5 Эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээ

12.5.1 Эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээг оношилгоо, эмчилгээний болон бусад батлагдсан стандарт технологи, эмнэлзүйн заавар, удирдамжийн дагуу 24 цагийн үйл ажиллагаа явуулахаар хүний нөөц, эм эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан байна.

12.5.2 Эрчимт эмчилгээний тусламж үзүүлэх ажилбарын жагсаалтыг мөрдөж ажиллана.

12.5.3 Эрчимт эмчилгээтэй үйлчлүүлэгчийн биеийн байдлыг холбогдох журмын дагуу хянаж, эрчимт эмчилгээний хяналтын хуудсанд тэмдэглэсэн байна.

12.5.4 Эрчимт эмчилгээ, мэс заслын болон мэс заслын дараах сэрээх өрөөнд эмнэлгийн хийн хангамжийн системтэй байна.

12.5.5 Эрчимт эмчилгээний хэсэг нь эмчлүүлэгчийн гэр бүлийнхнийг шаардлагатай үед байрлуулах, тавилга хэрэгсэл бүхий тав тухтай орчныг бүрдүүлсэн байна.

12.5.6 Эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээг мэргэжлийн эмч, сувилагчийн баг үзүүлнэ.

12.5.7 Эрчимт эмчилгээний тасаг, нэгжид ажлын бус цагийн жижүүрийг эрчимт эмчилгээний эмч гүйцэтгэнэ.

12.5.8 Эмнэлэг нь эрчимт эмчилгээ тасагт хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгчийн биеийн байдлын талаарх мэдээллийг 2 цаг тутамд хувь хүний нууцыг алдагдуулахгүй ар гэр, асран хамгаалагчид өгөх боломжийг бүрдүүлэн ажиллана.

12.6 Нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал, гамшгийн үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

12.6.1 Эмнэлэг нь гамшиг, онцгой байдал, газар хөдлөлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх нөхөн сэргээх төлөвлөгөөтэй ажиллана.

12.6.2 Төлөвлөгөөнд гамшиг тохиолдсон үед ажиллах нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн удирдлагын тогтолцоог байгуулан хэрэгжүүлэх, яаралтай, эрчимт эмчилгээ, мэс засал, осол гэмтлийн, нийгмийн эрүүл мэнд, сэтгэл зүйн тусламж үзүүлэх, нүүлгэн шилжүүлэх мэргэжлийн ангиудын томилгоо, хэрэгслийг тооцсон, байна.

12.6.3 Эмнэлэг нь гамшиг, онцгой байдлын үед ажиллах орон тооны бус Шуурхай удирдлагын бүтэц бий болгох, эмнэлгийн аюулгүй байдлын (барилга байгууламж, хүний нөөц, үйл ажиллагаа) үнэлгээ хийж, төлөвлөлтөнд тусган, хэрэгжилтийг хангана.

12.6.4 Гамшгийн үеийн нэрвэгдэгсдийг ангилан тэмдэглэх өнгийн таних тэмдэг, бүртгэлийн тогтолцоог бий болгосон байна.

12.6.5 Гамшиг, онцгой байдлын үед бусад төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, төрийн бусад байгууллага, иргэний нийгмийн байгууллага, сайн дурынхантай хамтран ажиллах албан ёсны гэрээтэй байна.

12.6.6 Гамшгийн бэлэн байдлын дадлага, сургуулилтыг орон нутгийн онцгой байдлын болон төрийн захиргааны байгууллага, бусад байгууллагатай хамтран жил бүр зохион байгуулна.

12.6.7 Гамшиг, онцгой байдлын үед нийтэд мэдээлэх дохиоллын системтэй, шаардлагатай хэрэгслээр хангагдсан байна.

12.6.8 Гамшиг, онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хуваарилалт, хангамжинд хяналт, үнэлгээ тогтмол хийнэ.

12.6.9 Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах, эрсдлийн үнэлгээ хийх чадавхи, гамшгийн үеийн нөөцийн санг бүрдүүлэх ажиллана.

12.6.10 Гамшиг, шинэ болон сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, тандах, тусламж үзүүлэх ажлыг зохион байгуулна.

12.7 Цус, цусан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, цус сэлбэлт судлал

12.7.1 Орон нутгийн нэгдсэн эмнэлгийн дэргэдэх Эмнэлгийн цус сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөл нь цусны салбар банкийн удирдлага, зохион байгуулалт, донорын үйлсийг сурталчлах, алдаршуулах, урамшуулах, цусны донор элсүүлэх, хянах, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинжлэх, хадгалах, тээвэрлэх, зохистой хэрэглэх ажиллагааг хангах ажлыг удирдлага арга зүйгээр хангаж ажиллана.

12.7.2 Цус цуглуулах, цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүнийг шинжлэх, хадгалах, тээвэрлэх, олгох, цус цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээнд

батлагдсан стандарт, фармокопейн өгүүлэл, тушаал, дүрэм, журам, шалгуур, зааврыг мөрдөж, шаардлагатай мэргэшсэн хүний нөөц, байр, тоног төхөөрөмжөөр хангана.

12.7.3 Цус, цусан бүтээгдэхүүнийг тээвэрлэх, хадгалах, сэлбэх аюулгүй ажиллагааны аргачлалд эмнэлгийн мэргэжилтнийг сургаж, мөрдүүлнэ.

12.7.4 Цус сэлбэлтийг зохицуулах салбар зөвлөл нь цус, цусан бүтээгдэхүүний чанар, аюулгүй ажиллагаанд хяналт тавин, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана.

12.7.5 Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэсэнтэй холбоотой гарсан урвал, хүндрэлийг зохих журмын дагуу бүртгэж мэдээлэх, сэргийлэх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлнэ.

12.7.6 Цусны аюулгүй байдалд хөндлөнгийн хяналт үнэлгээг жил бүр хийлгэж, үр дүнг тооцно.

12.8 Эмгэг судлалын тусламж, үйлчилгээ

12.8.1 “Эрүүл мэндийг хамгаалах технологи. “Цогцсын шинжилгээний арга, эмгэг судлалын оношийн бүтэц” Монгол Улсын стандарт, холбогдох журмыг мөрдлөг болгон ажиллана;

12.8.2 Эмнэлэгт нас барагчийн цогцост өвчин, үхэлд хүргэсэн шууд шалтгааныг тогтоох, тодорхойлох зорилгоор эмгэг судлалын шинжилгээ хийнэ. Эмгэг судлалын шинжилгээ, үйлчилгээг холбогдох дүрэм, журмын дагуу гүйцэтгэнэ.

12.8.3 Амьд сорьц, эмгэг эс судлалын шинжилгээг хийнэ.

12.9 Эмзүйн тусламж, үйлчилгээ

Эмийн сан нь эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчлүүлэгчийг хангах болон эм зүйн тусламж үйлчилгээ үзүүлнэ.

12.9.1 Эмнэлгийн эмийн сангийн үйл ажиллагаанд “Эмийн санд тавих нийтлэг шаардлага” Монгол Улсын стандарт, холбогдох журам, Эм зүйн албаны үлгэрчилсэн дүрмийг мөрдөнө.

12.9.2 Эмийн сан нь улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангана.

12.9.3 Эмнэлгийн эмэн эмчилгээг зохицуулах хороо нь үйлчлүүлэгчийг эмэн эмчилгээг үр дүнтэй аюулгүй, эдийн засгийн хувьд үр ашигтай эмээр тасралтгүй хүртээмжтэй хангах бөгөөд нотолгоонд суурилсан эмнэлзүйн эмзүйн тусламж, үйлчилгээг хүргэнэ.

12.9.4 Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн жор бичилт, жороор олгох, эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх, судлах, нян эмэнд тэсвэржихээс урьдчилан сэргийлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, үйлчлүүлэгчийг эмзүйн мэргэжил, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.

12.10 Түргэн тусламжийн үйлчилгээ

12.10.1 Эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх хүний нөөц, нэн шаардлагатай амин чухал эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, холбоо мэдээллийн хэрэгсэл, стандартын шаардлага хангасан зориулалтын тоноглогдсон автомашинаар хангагдсан байна.

12.10.2 Түргэн тусламжийн үйлчилгээг яаралтай тусламжийн чиглэлээр мэргэшсэн эмнэлгийн мэргэжилтэн, тухайн чиглэлээр сургагдсан эрүүл мэндийн бусад ажилтнаас бүрдсэн баг газар дээр болон эмнэлэг хүртэл үзүүлнэ.

12.10.3 Алсын түргэн тусламжийн үйлчилгээг мэргэжлийн баг гүйцэтгэнэ.

12.11 Уламжлалт анагаах ухаан

12.11.1 Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ холбогдох стандарт, эмнэлзүйн заавар, удирдамж, аргачлалын дагуу үзүүлнэ.

12.11.2 Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн хүний нөөц, өрөө тасалгаа, уламжлалт эм тан, эмнэлгийн хэрэгсэлээр хангагдсан байна.

12.11.3 Орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг хослуулан үзүүлнэ.

12.12 Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ

12.12.1 Хөнгөвчлөх эмчилгээний тусламж, үйлчилгээнд MNS 5455-2:2005 “Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ”-ний стандартыг мөрдөж ажиллана.

12.12.2 Хөнгөвчлөх эмчилгээтэй үйлчлүүлэгчийн асран хамгаалагч, ар гэрийнхэнд эмчилгээ, сувилгаа, асаргааны болон сэтгэл зүйн зөвлөлгөө өгнө.

12.13 Дотрын анагаах

Дотрын анагаах судлалаар бөөр, дотоод шүүрэл, зүрх, настан судлал, ревматологи, уушги, хоол боловсруулах тогтолцоо, хөнгөвчлөх, цус судлал, эмнэлзүйн хоол эмчилгээ, эмнэлзүйн хордлого, эмнэлзүйн эм судлалын төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

12.14 Мэдрэл судлал

Мэдрэл судлалд хүүхдийн мэдрэл судлалын төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

12.15 Хүүхэд

12.15.1 Хүүхдийн бие бялдар, өсөлт, хөгжил насны онцлогт нийцсэн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

12.15.2 Хүүхдийн насны онцлогоор нүд, амны хөндий, чих, хамар хоолой, зүрх судас, нөхөн үржихүй, сэтгэцийн эрүүл мэндийн болон бусад урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээ хийн, хяналтанд авч, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авна.

12.15.3 Хүүхдийн эрүүл мэндийн үндэсний бодлого хөтөлбөрийг хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажиллана.

12.16 Мэс засал

12.16.1 Мэс заслын тусламж, үйлчилгээний жагсаалтыг батлан хэрэгжүүлнэ.

12.16.2 Мэдээгүйжүүлгийг батлагдсан стандарт, заавар, удирдамжийн дагуу гүйцэтгэж, өвчтөний биеийн байдалд хяналт тавин, өвчний түүхэнд тэмдэглэнэ.

12.16.3 Мэс заслын эмчилгээний дараа үйлчлүүлэгчийн биеийн байдлыг тогтмол хянаж, өвчний түүхэнд тэмдэглэсэн байна.

12.16.4 Яаралтай мэс засал шаардлагатай үйлчлүүлэгчийг хүлээн авснаас хойш 2 цагийн дотор мэс засал хийх бэлтгэлийг хангана.

12.16.5 Мэс ажилбар, мэс засал хийхдээ үйлчлүүлэгчээс зөвшөөрлийг бичгээр заавал авах ба холбогдох хяналтын хуудсыг бөглөж, баталгаажуулна.

12.17 Гэмтэл согог

12.17.1 Осол гэмтлээс сэргийлэх, оношлох, эмчлэх, нөхөн сэргээх тусламж үйлчилгээг үзүүлнэ.

12.17.2 Гэмтэл согог сэргээн засах тусламж, үйлчилгээнд энэхүү стандартын 12.3-д заасан шаардлагыг дагаж мөрдөнө.

12.17.3 Мэс ажилбар, мэс заслын тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ энэхүү стандартын 12.16-д заасан шаардлагыг дагаж мөрдөнө.

12.18 Эх барих, эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээ

12.18.1 Жирэмсэнтэй хавсарсан эмгэгийг эрт илрүүлэн, эрсдэлтэй эмэгтэйг хянаж, мэргэжлийн эмчийн хяналтанд төрүүлнэ.

12.18.2 Төрөлтийн үед төрөлт, нярайн тусламж, үйлчилгээг багаар үзүүлэх ба шаардлагатай үед бусад мэргэжлийн эмч нартай хамтарч тусламж үзүүлнэ.

12.18.3 Нөхөн үржихүйн насны болон эрсдэлт бүлгийн эмэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг шинжилгээг төлөвлөгөөний дагуу холбогдох эрүүл мэндийн байгууллагатай хамтран хийж, үр дүнг тооцно.

12.18.4 Эх барих, нярай, эмэгтэйчүүдийн яаралтай тусламж үзүүлэх байнгын бэлэн байдлыг хангасан байна.

12.18.5 Жирэмсний болон төрсний дараах эх, нярайн тусламж, үйлчилгээний хяналт хийхэд мэргэжил арга зүйгээр хангана.

12.18.6 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн нэг цэгийн үйлчилгээний цогцолбор (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, өсвөр үе, жирэмсний хяналт, гэр бүл төлөвлөлт, сургалт, зөвлөгөө, мэдээлэл) ажиллуулан, үндэсний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож, Эрүүл мэндийн газарт мэдээлж, ажиллана.

12.18.7 Эхийн амрах байртай байх ба амрах байрны тав тух, тусламж, үйлчилгээний ээлтэй байдлыг хангаж ажиллана.

12.19 Халдварт өвчин

12.19.1 Халдварт өвчин судлалаар зонхилон тохиолдох халдварт өвчин, шинэ болон дахин сэргэж байгаа халдвар, зоонозын халдварт өвчин, БЗДХ, ХДХВ/ДОХ-ын төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

12.19.2 Халдварт ба зоонозын өвчний талбарын тархвар судлалын тандалтыг холбогдох стандарт, заавар, удирдамжийн дагуу хийж, халдвар тархахаас урьдчилан сэргийлж, хяналтанд авах үйл ажиллагааг зохион байгуулна.

12.19.3 Шинэ болон дахин сэргэж байгаа халдвар, зоонозын халдварт өвчний тусламж, үйлчилгээ үзүүлэх эм тариа, ариутгах, халдваргүйжүүлэх бодис, сорьц зөөвөрлөх сав болон хамгаалах хувцас, хэрэгслийн нөөцтэй, бэлэн байдлыг хангасан байна.

12.19.4 Үндэсний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ хийж, холбогдох байгууллагыг мэргэжил арга зүйгээр ханган, хамтран ажиллана.

12.19.5 Зоонозын халдварт өвчний сэжигтэй, болзошгүй тохиолдлыг хэвтүүлэн эмчлэх тусгаарлах өрөөтэй байна.

12.20 Сүрьеэ өвчний тусламж, үйлчилгээ

12.20.1 Эмнэлэг нь сүрьеэгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн хүний нөөц, механик агааржуулалтын систем бүхий эмэнд мэдрэг болон тэсвэртэй сүрьеэг тусгаарлан эмчлэх тасаг, өдрийн эмчилгээний цэг, диспансертай байна.

12.20.2 Халдвартай болон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөнг тусгаарлан сэргийлэлтийн арга хэмжээг баримтлан тасгийг зохион байгуулна.

12.20.3 Сүрьеэгийн халдвар тархахаас урьдчилан сэргийлж, хяналтанд авах үйл ажиллагааг зохион байгуулна.

12.20.4 Үндэсний бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, эрсдэлт бүлгийн хүн амд эрт илрүүлгийг зохион байгуулж, холбогдох байгууллагыг мэргэжил арга зүйгээр ханган, хамтран ажиллана.

12.20.5 Сүрьеэтэй өвчтөний эмчилгээг шууд хяналттай хийж, олон нийтийн оролцоог хангаж ажиллана.

12.21 Нүүр ам судлал

12.21.1 Эмнэлэг нь амны хөндийн эрүүл мэндийг дэмжих, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо хийж, эрүүлжүүлэх арга хэмжээ авна.

12.21.2 Шүдний үзлэг, оношилгоо, эмчилгээ, жижиг мэс ажилбар, эрүү нүүрний мэс засал, нүүр амны согог засал, гажиг засал зэрэг шүд, эрүү нүүрний тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

12.21.3 Гажиг, согог заслын зэмсэг хийх тусламж, үйлчилгээг үзүүлж болно.

12.22 Насжилт, настны эмгэг судлалын тусламж, үйлчилгээ

12.22.1 Орон нутгийн хэмжээнд эрүүл насжилт, нас дагаж гарах өөрчлөлт, настанд тохиолдох эмгэгийн чиглэлээр судалгаа, сургалт хийнэ.

12.22.2 Эмнэлэг нь насжилт, настны эмгэг судлалын тусламж, үйлчилгээний талаар холбогдох эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангаж, хамтран ажиллана.

12.22.3 Настны эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, эмчилгээг хийж, үр дүнг тооцно.

12.23 Өсвөр үеийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

12.23.1 Өсвөр үеийнхний насны онцлогт нийцүүлэн чих, хамар хоолой, нөхөн үржихүй, БЗДХ, сэтгэцийн эрүүл мэндийн болон бусад урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээг батлагдсан стандарт, эмнэлзүйн заавар, удирдамж болон аргачлалын дагуу хийж, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авна;

12.23.2 Орон нутгийн хэмжээнд өсвөр үеийн эрүүл мэнд, өсвөр насанд гарах өөрчлөлт, өсвөр үеийнхний дунд зонхилон тохиолдох өвчлөлийн чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулж, холбогдох эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангаж, хамтран ажиллана.

12.23.3 Өсвөр үеийн клиник ажиллуулан, тав тух, тусламж, үйлчилгээний ээлтэй байдлыг хангаж ажиллана.

12.24 Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

12.24.1 Сэтгэцийн эмгэг, наркологийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн хүний нөөц, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, өрөө тасалгаагаар хангагдсан байна.

12.24.2 Эмчлүүлэгчийг нийгэмшүүлэх, бие даах, хөдөлмөр, урлаг соёлын эмчилгээ хийх, сэтгэл зүй, сэтгэл заслын тусламж үйлчилгээг үзүүлнэ.

12.24.3 Хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо, эмчилгээ хийж, бусад байгууллагыг мэргэжил арга зүйгээр хангана.

12.24.4 Сэтгэцийн эмгэг, наркологийн тусламж, үйлчилгээ болон эмнэлгийн (барилга байгууламж, өрөө тасалгаа) аюулгүй байдлыг хангаж ажиллана.

12.25 Арьс, харшлын тусламж, үйлчилгээ

12.25.1 Арьс, харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо хийж, эмчлэн эрүүлжүүлнэ.

12.25.2 Арьс, харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээнд шинэ дэвшилтэт арга хэрэгсэл, технологи нэвтрүүлж, үр дүнг тооцож, ажиллана.

12.25.3 Арьсны архаг, удаан хугацаагаар нөхөх эмчилгээ шаардлагатай өвчтөнийг хяналтад авч, эмчилнэ.

12.26 Нүдний тусламж, үйлчилгээ

12.26.1 Зонхилон тохиолдох нүдний өвчин болон нүдний даралт ихдэх өвчтэй хүмүүсийг бүрэн хяналтанд авч, эмчилнэ.

12.26.2 Зонхилон тохиолдох нүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоог холбогдох эрүүл мэндийн байгууллагатай хамтран хийж, эмчилнэ.

12.26.3 Нүдний эрүүл ахуй, хараагаа хамгаалах зөв дадал, заншилд хүн амыг сургахад холбогдох эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллана.

12.27 Чих, хамар хоолойн тусламж, үйлчилгээ

12.27.1 Зонхилон тохиолдох чих, хамар хоолойн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоо хийж, хяналтанд авч эмчилнэ.

12.27.2 Чих, хамар хоолойн тусламж, үйлчилгээнд шинэ дэвшилтэт арга хэрэгсэл, технологи нэвтрүүлж, үр дүнг тооцож, ажиллана.

12.28 Хавдрын тусламж, үйлчилгээ

12.28.1 Бүх хоргүй хавдрын мэс заслын эмчилгээ, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ, хими болон даавар эмчилгээ, зарим төрлийн хорт хавдрын хөнгөвчлөх мэс заслын эмчилгээ, хэвлийн хөндийн дурангийн мэс засал хийнэ.

12.28.2 Хавдрын урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн оношилгоо, эмчилгээ хийж, үр дүнг тооцно.

12.28.3 Хүн амын дунд хавдрын эрсдэлт зан үйлийг бууруулах, эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

12.28.4 Хими эмчилгээ хийх аюулгүй ажиллагааны шаардлага хангасан ламинар бокстой байна.

13 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

13.1 Тандалт судалгаа, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

13.1.1 Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд холбогдох мэргэжлийн байгууллагаас удирдлага, мэргэжил арга зүйн дэмжлэг авч, үндэсний хөтөлбөр, бодлогыг хэрэгжүүлж ажиллана.

13.1.2 Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа нь зонхилон тохиолдох өвчин эмгэг, осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчин, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, тэдгээрийг эрт илрүүлэх, тандалт судалгаа, хяналт хийх, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгоход чиглэнэ.

13.1.3 Зонхилон тохиолдох өвчин эмгэг, өвчлөл, осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалсан өвчин, тархалтын хандлага, эрсдэлт хүчин зүйлийг тандан судалж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.

13.1.4 Нийгмийн эрүүл мэнд, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрүүл мэндийн бусад байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийт, иргэдтэй хамтран ажиллаж, салбар дундын болон олон улсын байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтын ажиллагааг өрнүүлнэ.

13.1.5 Нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг, оношилгоог улсын хэмжээнд зохион байгуулж, харьяа дээд шатны байгууллагад тайлагнана.

13.1.6 Үйлчлүүлэгчид зонхилон тохиолддог өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг зохион байгуулна.

13.1.7 Эмнэлгийн номын сан нь үйлчлүүлэгчид эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөөг хүргэх ном, зөвлөмж, гарын авлагаар хангагдсан, үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.

13.1.8 Эмнэлгийн мэргэжилтнийг зөвлөгөө өгөх ур чадварт сургах ажлыг тогтмол зохион байгуулна.

14 Дэмжих үйлчилгээ

14.1 Нийгэм-сэтгэлзүй, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ

14.1.1 Үйлчлүүлэгч, түүний ар гэрийнхэн болон эмнэлгийн мэргэжилтэнд эвлэрүүлэн зуучлах, хууль зүйн болон нийгэм-сэтгэлзүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ өгөх нөхцлийг бүрдүүлсэн байна.

14.1.2 Үйлчлүүлэгч, ар гэрийнхэнд нийгэм, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг мэргэжлийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан шаардлагатай тохиолдолд үзүүлнэ.

14.1.3 Нийгэм сэтгэлзүй, хууль зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг энэхүү стандартын шаардлага хангасан нөхцөлд холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн үндсэн орон тоогоор болон гэрээгээр гүйцэтгүүлж болно.

14.1.4 Эмнэлгийн мэргэжилтэн нь үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээний талаар болон эрүүл мэндийн зөвлөгөөг ойлгомжтой энгийн үг хэллэгээр өгнө.

14.1.5 Зөвлөгөө өгөх, харилцааны ур чадварт эмнэлгийн мэргэжилтэнг сургаж, ажлын гүйцэтгэл, үнэлгээтэй уялдуулна.

14.2 Хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн үйлчилгээ

14.2.1 Эмнэлгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ нь хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгчдэд зориулсан эмчилгээний хоол үйлдвэрлэл болон шим тэжээлийн үйлчилгээ гэсэн үндсэн 2 хэсгээс бүрдэнэ.

14.2.2 Эмчилгээний хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бүхэлд нь болон зарим хэсгийг энэхүү стандартын шаардлага хангасан нөхцөлд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

14.2.3 Эмчилгээний хоол үйлдвэрлэл, үйлчилгээг “Эрүүл мэндийн технологи. Зонхилон тохиолдох өвчний үеийн хоол” Монгол Улсын стандарт болон “Эмчилгээ, сувиллын хоолны удирдамж”-ийн дагуу гүйцэтгэнэ.

14.2.4 Эмчилгээний хоолны арга техник, үйлчилгээний онцлогт нийцүүлэн дэвшилтэт арга технологийг нэвтрүүлэн ажиллана.

14.2.5 Тасаг нь батлагдсан удирдамж, заавар, жор, технологиор хоолны илчлэг, орц, нормыг тооцон, эрүүл ахуйн шаардлага хангасан эмчилгээний хоолоор үйлчлэх ба хоол түгээх үйл ажиллагаанд эмчилгээний хоолны аяга, таваг хэрэглэнэ.

14.2.6 Шим тэжээлийн үйлчилгээ нь үйлчлүүлэгчид шим тэжээлийн үнэлгээ, зөвлөгөө, сургалт, сурталчилгаа болон судалгааг тогтмол хийж үйл ажиллагааг хянаж сайжруулна.

14.2.7 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд дотоодын хяналтыг тогтмол хийнэ.

14.2.8 Амбулаториор үйлчлүүлэгч, эмчлүүлэгчийн ар гэр, сахиурт зориулсан нийтийн хоол үйлдвэрлэл нь “Нийтээр нь үйлчлэх хоол, үйлдвэрлэл үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн дадал”, “Хоолны газрын ангилал, зэрэглэл, шаардлага” стандарт болон бусад холбогдох стандарт, дүрэм, журмын дагуу гүйцэтгэнэ.

14.3 Эмнэлгийн тоног төхөөрөмж, инженерийн байгууламж

14.3.1 Эмнэлгийн тоног төхөөрөмж, инженерийн байгууламжийн үйлчилгээг холбогдох дүрэм, журмын дагуу мэргэжлийн инженер, техникийн ажилтан хийж гүйцэтгэнэ.

14.3.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн болон инженерийн байгууламжийн инженер, техникийн ажилтан нь тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны мэргэжлийн удирдлагаар хангаж, сургалтыг зохион байгуулна.

14.3.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн өдөр тутмын үзлэг, шалгалт, төлөвлөгөөт засвар, үйлчилгээ, тохиргоог үйлдвэрлэгчээс гаргасан зааврын дагуу хийж,

ашиглалтын аюулгүй ажиллагааг хангаж, техник ашиглалтын паспортод тэмдэглэл хөтөлнө.

14.3.4 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн нарийн мэргэжлийн засвар үйлчилгээ, угсралт суурилуулалт шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

14.3.5 Өөрийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, цахим системд олон улсын нэршил, эрсдэлийн ангиллын дагуу бүртгэн, өөрчлөлтийг тухай бүр хийж, мэдээллийн санг бүрдүүлнэ.

14.3.6 Шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалтыг мэргэжлийн байгууллагаар холбогдох хууль, журмын дагуу хийлгэсэн байна.

14.3.7 Энэхүү стандартын 14.3.6-д заасан шалгалт тохируулга, шалгалт баталгаажуулалт хийлгээгүй, түүнд тэнцээгүй эсхүл гэмтэлтэй тоног төхөөрөмжийг оношилгоо, эмчилгээнд ашиглахыг хориглоно.

14.3.8 Тоног төхөөрөмжийг актлах, урсгал, төлөвлөгөөт засварт оруулах, шинээр шаардлагатай байгаа тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн судалгаа захиалгыг гаргаж мөрдөж ажиллана.

14.3.9 Механик, электрон болон бохирдсон тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний тус тусын өрөөтэй байх ба шаардлагатай тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ, хяналт тохируулгын багаж хэрэгслээр хангагдсан байна.

14.3.10 Шаардлагатай тасаг нэгжид хүчилтөрөгч, шахсан агаар, вакум зэрэг хийн хангамжийн системтэй байх ба холбогдох стандарт, заавар, журмын дагуу аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллана.

14.3.11 Эмнэлгийн, эмнэлгийн бус тоног төхөөрөмж нь газардуулгын системд холбогдсон байх, мэргэжлийн байгууллагаар хяналт баталгаажуулалт хийлгэсэн байна.

14.3.12 Эмнэлгийн цахилгаан хангамж нь тогтвортой, хэлбэлзэлгүй байх ба цахилгааны гадны болон дотоодын нөөц эх үүсгүүртэй байна.

14.3.13 Мэс засал, яаралтай тусламж, лаборатори зэрэг эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай тоног төхөөрөмж нь хүчдэл тогтворжуулан барих төхөөрөмжтэй байна.

14.3.14 Үйлчлүүлэгч, үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдал, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангасан, төрөлжсөн лифттэй байна.

14.3.15 Эмнэлэг нь ердийн болон тусгай зориулалтын агааржуулалтын системтэй байна.

14.3.16 Шаардлагатай тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчээс гаргасан шаардлагын дагуу цэвэршүүлсэн усан хангамжийн системд холбосон байна.

14.3.17 Эмнэлэг нь стандартын шаардлага хангасан халаалтын системтэй байна.

14.3.18 Эмнэлэг нь стандартын шаардлага хангасан гэрэлтүүлгийн системтэй байна.

14.3.19 Эмнэлэг нь сувилагчийн болон тусгай зориулалтын дуудлага, дохиололын системтэй байна.

14.4 Санхүү, аж ахуй, хангамж

14.4.1 Санхүү, аж ахуй хангамж, үйлчилгээний хуваарь, төлөвлөгөөтэй, хэрэгжилтийг хангаж ажиллана.

14.4.2 Санхүү, аж ахуй хангамжийн үйл ажиллагаа нь эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шаардагдах бараа, бүтээгдэхүүний хангамжийн бэлэн байдлыг хангаж, эрүүл ахуйн шаардлагыг хангасан аюулгүй бүтээгдэхүүн нийлүүлэлтийг зохих хууль, журмын дагуу хийнэ.

14.4.3 Санхүү, аж ахуй хангамжийн зарим үйлчилгээг энэхүү стандартын шаардлага хангасан нөхцөлд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

14.5 Түргэн тусламжийн автомашин парк

14.5.1 Тээврийн зарим үйлчилгээг энэхүү стандартын шаардлага хангасан нөхцөлд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

14.5.2 Түргэн тусламжийн автомашин нь тоноглогдсон, амин чухал эм, эмнэлгийн хэрэгсэл, холбогдох стандарт, журамд заасан багаж, тоног, төхөөрөмжөөр хангагдсан байна.

14.5.3 Автомашины тоо нь үйлчлэх хүрээний хүн амын тоо, алслагдсан байдал, өвчлөлөөс хамааран хүлээгдэлгүй үйлчлэх, хүрэлцэхүйц тооны байна.

14.5.4 Шаардлага хангасан дулаан гражтай байна.

14.5.5 Тээврийн хэрэгслийн ашиглалт, эдэлгээ, засвар үйлчилгээний судалгааг жил бүр гаргаж, шинэчлэл хийнэ.

14.6 Мэдээллийн технологи, харилцаа холбоо

14.6.1 Мэдээллийн технологи, харилцаа холбооны техник, тоног төхөөрөмж, хангамж, үйлчилгээний инженерийн хэсэгтэй байна.

14.6.2 Мэдээллийн технологи, харилцаа холбооны зарим үйлчилгээг энэхүү стандартын шаардлага хангасан нөхцөлд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

14.6.3 Мэдээллийн технологи, харилцаа холбооны хэсэг нь эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанг техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, журмаар хангаж, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна.

14.6.4 Мэдээллийн технологи, харилцаа холбооны техник, тоног төхөөрөмжийн инженер нь засвар үйлчилгээг төлөвлөгөө, хуваарийн дагуу гүйцэтгэж, техник ашиглалтын тэмдэглэгээ хөтөлнө.

14.6.5 Тусламж, үйлчилгээнд шаардлагатай, дэвшилтэт технологи бүхий харилцаа холбооны хэрэгслээр бүрэн хангагдсан байна.

14.6.6 Харилцаа холбооны техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, эдэлгээ, засвар үйлчилгээний судалгааг жил бүр гаргаж, шинэчлэл хийнэ.

14.7 Төвлөрсөн ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ

14.7.1 Ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээ явуулах төвлөрсөн ариутгалын тасаг/хэсэгтэй байна. Ариутгал, халдваргүйтгэлийн үйлчилгээг энэхүү стандартын шаардлага хангасан нөхцөлд холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

14.7.2 Ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагаанд эрүүл ахуйн шаардлага, халдварын сэргийлэлт, хяналтын дэглэмийг мөрдөж, холбогдох журам, зааврыг мөрдөж ажиллана.

14.7.3 Төвлөрсөн ариутгалын ажилтан нь халдварын сэргийлэлт, хяналт, халдваргүйтгэх, ариутгах, шавж, мэрэгч устгах чиглэлээр сургалтанд хамрагдсан гэрчилгээтэй байна.

14.7.4 Ариутгах, халдваргүйжүүлэх техник, тоног төхөөрөмж нь аюулгүй ажиллагааны стандартын шаардлагыг бүрэн хангасан байна.

14.7.5 Төвлөрсөн ариутгалын хэсэг нь нэг чиглэлийн урсгалтай, бохир, цэвэр, ариун гэсэн 3 бүсэд хуваагдах бөгөөд бохир багаж, хэрэгсэл, материалыг хүлээн авах, угаалга, халдваргүйжүүлэлт хийх, хатаах, засварлах, боох, савлах, ариутгах,

ариун багаж, материал хадгалах зэрэг зориулалтын өрөөтэй, цэвэр, бохир усны шугамд холбогдсон байна.

14.7.6 Төвлөрсөн ариутгалын хэсгийн өрөөний гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай, ариун хэсгээс бохир хэсэг руу чиглэсэн төвлөрсөн болон хэсгийн агааржуулалтын системтэй, бохир хэсгийн өрөөг агаарын сөрөг даралттай, цэвэр болон ариун өрөөг агаарын эерэг даралттай байхаар зохион байгуулсан байна.

14.7.7 Ариутгалын газрын өрөө, тасалгааны шал нь хальтардаггүй, цахилгаанждаггүй, хана нь угааж цэвэрлэхэд тохиромжтой материалаар хийгдсэн байна. Шал–хана, тааз-ханын уулзвар ирмэг нь мохоо, хийц материал нь цайвар өнгөтэй, цэвэрлэхэд тохиромжтой, зай завсаргүй, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

14.7.8 Ариутгалын чанарт дотоодын хяналтыг тогтмол тавина.

14.7.9 Ариутгал хийсэн тухай бүртгэлийг тогтмол хөтөлнө.

14.7.10 Бохир, цэвэр материал хадгалах шүүгээ савтай байна.

14.8 Угаалга, цэвэрлэгээ

14.8.1 Угаалга, цэвэрлэгээнд холбогдох эрүүл ахуйн шаардлага, халдварын сэргийлэлт хяналтын дэглэмийг мөрдөж ажиллана.

14.8.2 Угаалга, цэвэрлэгээний үйлчилгээг энэхүү стандартын шаардлага болон “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага”-ыг хангасан нөхцөлд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

14.8.3 Угаалгын газар нь нэг чиглэлийн урсгалтай, бохир, цэвэр хэсэгтэй байна. Бохир хэсэгт бохир хэрэглэлийг ангилан ялгах, угааж халдваргүйжүүлэх, цэвэр хэсэгт индүүдэх, засварлах, хадгалах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

14.8.4 Угаалгын газрын өрөө тасалгаа нь гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай, цэвэр, бохир усны шугамд холбогдсон, зөөврийн усан хангамжтай үед угаалгын үйлчилгээнд хүрэлцэхүйц хэмжээний ус нөөцлөх савтай, ус зөөвөрлөх, халаах хэрэгслээр хангагдсан байна.

14.8.5 Угаалгын хэсгийн шал нь халтиргаа, гулгаа үүсгэхгүй, өнгө үзэмжтэй, эрүүл ахуйн, аюулгүй байдлын шаардлага хангасан, цахилгаанждаггүй зориулалтын материалаар хийгдсэн байна. Шал–хана, тааз-ханын уулзвар ирмэг нь мохоо, хийц материал нь цайвар өнгөтэй, цэвэрлэхэд тохиромжтой, зай завсаргүй, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

14.8.6 Цэвэр хэрэгслийг шалнаас дээш 10-15 см өргөгдсөн, хангалттай хэмжээний тавиур бүхий шүүгээнд хадгална.

14.9 Эмнэлгийн дохиолол, хамгаалал

14.9.1 Дохиолол, хамгаалалтын нэгжтэй, онцгой объектод камер байршуулсан, шаардлагатай холбооны хэрэгсэл, бусад тоног төхөөрөмж хангагдсан, мэдээллийн тогтолцоотой байна.

14.9.2 Дохиолол, хамгааллын үйлчилгээг энэхүү стандартын шаардлага хангасан нөхцөлд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

14.10 Эмнэлгийн хог хаягдал

14.10.1 Эмнэлгийн аюултай хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэх, устгахад холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллана.

14.10.2 Эмнэлгийн аюултай хог хаягдал түр хадгалах зориулалтын байртай байх ба хогийн сав нь Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

14.10.3 Эмнэлэг нь аюултай хог хаягдлын зарим үйлчилгээг энэхүү стандартын шаардлага хангасан нөхцөлд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

15 Эрүүл ахуйн шаардлага

15.1 Эмнэлгийн байгууллагын гадаад болон дотоод орчны эрүүл ахуйн шаардлага

15.1.1 Эмнэлгийн гадаад болон дотоод орчны эрүүл ахуйн шаардлагыг “Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” стандартын дагуу мөрдөнө.

15.1.2 Хүний эрүүл мэндэд харшил үүсгэдэггүй ногоон мод, бутыг сонгон, барилгаас 6-10 метрийн зайд, 2 цонхны хоорондох хананы тушаа, өндөр ургасан үедээ цонхонд бүдэг сүүдэрлэлт үүсгэх, харшлын бодис саармагжих орчинд тарина.

15.1.3 Гадна талбайд зонхилох салхины доод зүгт, талбайн сандлаас 1,5-2 метрийн зайд, 30 метр тутамд хогийн сав байхаар төлөвлөх ба хогийн сав нь Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

15.1.4 Гадна орчны тохижилт, барилга, байгууламж, өрөө, тасалгаа нь хөдөлмөр, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байна.

15.1.5 Барилгын цонх, хаалга нь зориулалтын хаалт, сүүдэрлэлтэй, цайвар өнгөтэй, битүүмжлэл сайтай, бүрэн ажиллагаатай, түгжээтэй, гадагшаа онгойдог байна.

15.1.6 Эмнэлгийн хана нь тусламж, үйлчилгээний онцлогоос хамааран (төрөх, сэтгэц, мэдрэл, нүд гэх мэт) харааны мэдрэлийн цочролоос сэргийлсэн, оношилгоо, эмчилгээнд сөрөг нөлөөгүй өнгөтэй байх ба эрүүл ахуйн шаардлага хангасан байна.

15.1.7 Эмнэлгийн гадна болон дотор талын шал нь халтиргаа, гулгаа үүсгэхгүй, өнгө үзэмжтэй, эрүүл ахуйн, аюулгүй байдлын шаардлага хангасан, зориулалтын хавтанцраар хийгдсэн байна.

15.1.8 Ариун цэврийн байгууламж нь төвлөрсөн системд холбогдсон байна.

15.1.9 Яаралтай, эрчимт эмчилгээний тасаг нь үйлчлүүлэгч (ор бүхий)-ийг орох, гарахад (босгогүй) саадгүй байх нөхцлийг хангасан мэс заслын хэсгийн хаалга био мэдрэгч бүхий автомат ажиллагаатай байна.

15.1.10 Эмнэлгийн барилгын дээвэр ба ханын гадна тал нь ус нэвтэрдэггүй, дотор тал нь агаар чийгний нөлөөллөөс хамгаалагдсан байна.

15.1.11 Төрөх, нярай, мэс засал, эрчимт эмчилгээ, лаборатори, боолт, тарианы өрөө, ариутгалын хэсэг, хоол үйлдвэрлэл зэрэг тасаг нэгжид жил бүр урсгал засварыг тогтмол хийнэ.

15.1.12 Барилга байгууламжийн байршил, галын болон аюулгүй ажиллагааны урсгал хөдөлгөөнийг харуулсан тойм зургийг нийтэд харагдахуйц газар байрлуулсан байна.

15.1.13 Эмнэлэг нь тасаг, нэгжийн ариун цэврийн өрөөнд гар угаах халуун, хүйтэн ус бүхий угаалтуур, нянгийн эсрэг үйлчилгээтэй шингэн саван, гар арчих нэг удаагийн хэрэглээний алчуур, гар халдваргүйжүүлэх бодисоор хангагдсан байна.

15.1.14 Мэс засал, төрөх, нярайн тасаг нэгж болон ажилбарын өрөөнд мэдрэгчтэй эсвэл, хөл, тохойг ашиглан нээж, хаах ажиллагаатай гарын угаагууртай байна.

15.1.15 Мэс заслын хэсгийн өрөөний шал нь цахилгаанждаггүй материалаар хийгдсэн, хана нь тосон будаг эсвэл шаазан хавтан, таазыг эмульсээр будсан байна. Шал–хана, тааз-ханын уулзвар ирмэг нь мохоо, хийц материал нь цайвар өнгөтэй, цэвэрлэхэд тохиромжтой, зай завсаргүй байна.

15.1.16 Стандартын шаардлага хангасан агуулах болон архивын өрөөтэй байна.

15.1.17 Рентген болон цөмийн оношилгоо, эмчилгээний өрөөний хана, шал, тааз, хаалга, цонх нь туяанаас хамгаалагдсан тусгай зориулалтын байна. Радиацийн түвшинг холбогдох байгууллагаар хэмжүүлэн, баталгаажуулалт хийсэн байна.

15.1.18 Эмгэг судлалын хэсэг нь эмчилгээний байрнаас тусдаа байрлалтай, цонхыг цагаан, цайвар өнгөөр сүүдэрлэсэн, автомат агааржуулалтын системтэй, зориулалтын дагуу тоноглогдсон, тусгай өрөөтэй байна.

15.2 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний эрүүл ахуйн шаардлага

“Эрүүл мэндийн байгууллагын орчны эрүүл ахуйн шаардлага” стандартын хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдлын хэсгийг дагаж мөрдөнө.

15.3 Хатуу, зөөлөн эдлэлийн эрүүл ахуйн шаардлага

15.3.1 Ор бүхэн тоос, чииг татдаггүй, жигд гадаргуутай матрацтай, цагаан хэрэглэл нь эрүүл ахуйн шаардлага хангасан.

15.3.2 Эрүүл ахуйн шаардлага хангасан, угааж цэвэрлэхэд хялбар, өнгө үзэмжтэй, бат бөх хийцтэй ширээ, сандал, шүүгээтэй байна.

15.3.3 Хатуу, зөөлөн эдлэлийн хэрэглээнд жил бүр тогтмол үзлэг, тооллого хийж, эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон эд зүйлийг актлан устгаж, шинээр нөхөн хангалт хийнэ.

15.3.4 Мэс засал, халдварт, төрөх, нярай, эрчимт эмчилгээний тасгийн үйлчлүүлэгч хавсралтанд заасан хувцас, хэрэглэлтэй байна.

15.4 Ажлын байр, ажилтны хувцас, хэрэгслийн эрүүл ахуйн шаардлага

15.4.1 Ажлын байранд “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага” стандарт болон Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад стандарт технологийг мөрдөнө.

15.4.2 Тусламж, үйлчилгээний онцлогоос хамааран эмнэлгийн ажилтан нь таних тэмдэг, өнгө бүхий ажилтны нормын хувцас, хэрэглэлээр бүрэн хангагдсан байх ба материал нь эрүүл ахуйн болон чанарын шаардлага хангасан байна.

15.4.3 Ажилтан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийг зохих журмын дагуу өмсөж, эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангаж ажиллана.

15.4.4 Ажилтанд зориулсан эрүүл ахуйн шаардлага хангасан тав тухтай амрах байр, усанд орох болон хувцас солих өрөөтэй байна.

15.5 Хүүхэд, настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орчны эрүүл ахуйн шаардлага

15.5.1 Хүүхэд, настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд стандартын дагуу ээлтэй орчин (өвөрмөц хэрэгцээг хангах налуу зам, босгогүй хаалга, тоглоомын булан) бүрдүүлж ажиллана.

15.5.2 Хүүхэд, настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулагдсан тусгай нөхцөл шаардлагыг тасаг, нэгж бүр (тусгай зориулалтын ариун цэврийн өрөө, хана дагасан бариул, тэргэнцэр, түшлэг гэх мэт) хангана.

15.5.3 Тээврийн хэрэгслийн зогсоолын талбайд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тэмдэглэгээ хийнэ.

16 Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал

16.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх үйл ажиллагаа

16.1.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй стандарт технологи болон холбогдох дүрэм, журам, заавар, аргачлалыг мөрдөж ажиллана.

16.1.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвараас сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохицуулах чиг үүрэг бүхий халдварын сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан нэгжтэй байна.

16.1.3 Эрүүл ахуйн нөхцөл, халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаанд шинэлэг арга хэрэгслийг нэвтрүүлж ажиллана.

16.1.4 Халдварын сэргийлэлт, хяналтын асуудал хариуцсан нэгж нь халдвараас сэргийлэх тушаал, заавар, журмын хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийж, гүйцэтгэлийг хянана.

16.1.5 Ариутгах, халдваргүйжүүлэх болон эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтыг нийт ажилтанд жил бүр, шинээр ажилд орж байгаа ажилтанд тухай бүр зохион байгуулж, мэдлэг, дадал, ур чадварыг эзэмшүүлэн, баталгаажуулна.

16.1.6 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэг удаагийн зориулалтын хэрэгслийн хүрэлцэхүйц хэмжээний нөөцтэй байна.

16.1.7 Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын сэжигтэй тохиолдлыг илрүүлэх идэвхитэй тандалтыг тогтмол хийж, сэжигтэй болон онош батлагдсан тохиолдол бүрийг бүртгэн, журмын дагуу мэдээлж, хариу арга хэмжээг авна.

16.1.8 Төрөх, мэс засал болон түүнтэй адилтгах тасаг нэгжид идээт үрэвсэлтэй, халуунтай эмч, ажилтныг өвчин эдгэртэл ажилд гаргахыг түр хориглож, хөдөлмөр зохицуулалт хийнэ.

16.1.9 Эмнэлгийн орчны эд юмс, ариун багаж материалаас арчдас, төрөх өрөө, хагалгааны блок, боолт, тариа, нярай, эрчимт эмчилгээ, лаборатори зэрэг эрсдэл бүхий тасаг, нэгжийн өрөөний агаарт нян судлалын шинжилгээг эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын дэгдэлт гарсан тохиолдолд хийнэ.

16.1.10 Өрөөний дулаан ба агаар солилцооны дэглэмийг баримтлан, цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт, шавж, мэрэгч устгах үйл ажиллагааг батлагдсан журам, хуваарийн дагуу мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, хяналт тавина.

16.1.11 Үйлчлүүлэгчийн мөрдөх эрүүл ахуй, халдварын сэргийлэлт хяналтын дотоод журмыг батлан хэрэгжилтэнд хяналт тавина.

16.1.12 Тусгаарлах өрөөнд олон улсын дүрмээр зохицуулагдах өвчинтэй үйлчлүүлэгчид тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ холбогдох журам, зааврын дагуу арга хэмжээ авна.

16.1.13 Халдвараас урьдчилан сэргийлэх, голомтын халдваргүйтгэл хийх багаж хэрэгсэл, улсын бүртгэлд бүртгэгдсэн ариутгал, халдваргүйтгэлийн бодисоор тасралтгүй хангана.

16.2 Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал

16.2.1 Үйлчлүүлэгчийн аюулгүй байдалд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт технологи болон холбогдох дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллана.

16.2.2 Байгууллагын удирдлага үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд чанарын болон халдвараас сэргийлэх хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, үр дүнг тооцно.

16.2.3 Үйлчлүүлэгчийн зан заншил, хэл яриа, өвөрмөц аялга, үнэт зүйлс, итгэл үнэмшил, шашин шүтлэг, хувийн нууцлалыг хүндэтгэн харилцана.

16.2.4 Үзүүлэх гэж буй тусламж, үйлчилгээний талаар үйлчлүүлэгчид ойлгомжтой хэлбэрээр урьдчилан тайлбарлан, батлагдсан маягтаар таниулсан зөвшөөрөл авна.

16.2.5 Үйлчлүүлэгч, түүний ар гэр, сахиурт эмнэлгийн эмчилгээ, үйлчилгээ, эрүүл ахуй, халдвар хамгаалал, аюулгүй ажиллагаа, дотоод дүрэм, журмын талаар

тодорхой мэдээлэл өгч, эдгээрийг баримтлан, өөрийн аюулгүй байдалдаа хяналт тавих нөхцөл бололцоогоор хангана.

16.2.6 Үйлчлүүлэгчид оношилгоо, шинжилгээний аюултай хариуг мэдэгдэхийн өмнө үйлчлүүлэгчийг таних үйл ажиллагаа хийгдсэн байна.

16.2.7 Үйлчлүүлэгчийн эд зүйлс алдагдахаас сэргийлэх сэрэмжлүүлгийн тэмдэглэгээ байршуулах, нийтийн орчныг камержуулах, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

16.2.8 Байгууллагын ажилтан бүр амилуулах суурь тусламж үзүүлэх чадвар эзэмшсэн байна.

16.3 Ажилтны аюулгүй байдал

16.3.1 Ажилтны аюулгүй байдалд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандарт технологи болон дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллана.

16.3.2 Ажилтны эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой эрсдэлээс сэргийлэх, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр ханган, үр дүнг тооцож ажиллана.

16.3.3 Эрүүл мэндийн ажилтныг жил бүр, шинээр ажилд орж байгаа хүмүүсийг тухай бүр урьдчилан сэргийлэх үзлэг болон сүрьеэ, гепатит В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамруулан, эрүүлжүүлэх арга хэмжээг авна.

16.3.4 Шаардлагатай үед ажилтанг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөсөн томуугийн шинэ вирусийн халдварын болон улаанууд, гэдэсний балнад, тарваган тахал зэрэг вакцинд зохих хууль тогтоомж, шийдвэрийн дагуу хамруулна.

16.3.5 Мэргэжлээс шалтгаалсан осол, гэмтэл, өртөлт (хурц үзүүртэй зүйлд хатгагдах, цус цусан бүтээгдэхүүн арьс салстад үсрэх гэх мэт), өвчлөлийг илрүүлэн бүртгэж, тохиолдол бүрийг тасаг, нэгжийн албаны даргад мэдээлэн, арга хэмжээ авна.

16.3.6 Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанд зориулсан эрүүл ахуйн шаардлага хангасан хувцас солих, хооллох, усанд орох өрөөтэй байна.

16.3.7 Ажилтан нь тухайн ажил мэргэжлийн онцлогт тохирсон аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн 2-оос доошгүй ээлжийн ажлын хувцас, нэг удаагийн хамгаалах хэрэгслийг хүрэлцэхүйц хэмжээгээр хангагдана.

16.4 Ажлын байр, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдал

16.4.1 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг үнэлэх, үнэлгээг хийхэд ажилтны оролцоог нэмэгдүүлж, үнэлгээний дүнг үндэслэн хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллана.

16.4.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчээс гаргасан ашиглалтын гарын авлага болон холбогдох аюулгүй ажиллагааны дүрэм, журмын дагуу зохих сургалтад хамрагдсан эмнэлгийн ажилтан ашиглана.

16.4.3 Эмнэлгийн болон эмнэлгийн бус тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны зааврыг Монгол хэл дээр боловсруулж, тухайн ажлын байранд харагдахуйцаар, байрлуулна.

16.4.4 Ажилтанд хөдөлмөрийн дотоод журам, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгааг албан ёсоор танилцуулж, баталгаажуулсан байна.

16.4.5 Цацраг идэвхит бодис, хүчил шүлт, тэсэрч дэлбэрэх бодистой ажиллахдаа батлагдсан заавар, дүрэм, журмыг мөрдөж ажиллана.

16.4.6 Цацраг идэвхит үүсгүүр, эмнэлгийн хийн хангамжийн болон дамжуулах системийн аюулгүй байдлыг мэргэжлийн байгууллагаар хянуулан, баталгаажуулсан байна.

16.4.7 Ажлын байр нь үйлчлүүлэгч, ажилтны аюулгүй зохимжтой урсгал хөдөлгөөнийг харуулсан зураг, схем, дохио тэмдэглээтэй байна.

16.5 Галын аюулгүй байдал

“Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Галын аюулгүй байдал. Техникийн шаардлага”-ын стандарт болон бусад галын аюулгүй байдлын шаардлагыг тодорхойлсон стандарт, техникийн нормативыг чанд мөрдөж ажиллана.

ТӨГСӨВ.

А хавсралт (Норматив)

Хүний нөөцийн орон тоо

А1 Эмнэлэг нь тусламж, үйлчилгээг хэвийн явуулахад хүний нөөцийн дараахь үндсэн шаардлагыг биелүүлж ажиллана:

А1.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээг гардан үзүүлдэг эмнэлгийн мэргэжилтэн¹, тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шууд оролцдог эмнэлгийн бусад мэргэжилтэн² болон захиргаа, аж ахуйн үйлчилгээний ажилтны харьцаа **70%-75% : 30%-25%** байна.

А1.2 Зөвхөн хууль, журмын дагуу олгосон **мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй**³ эмнэлгийн мэргэжилтэн тухайн зөвшөөрлийн төрлөөр эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

А1.3 Эмнэлгийн тусламж, үйлчилгээг гардан үзүүлж байгаа их эмч болон сувилагч (бакалаврын, дипломын, туслах)-ийн харьцаа **1:2,0-2,5**-аас багагүй байна.

А1.4 Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд гардан оролцож байгаа сувилагч (бакалаврын, дипломын) болон туслах сувилагчийн харьцаа **4:0,5-1**-ээс багагүй байна.

А1.5 Лабораторийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эмнэлзүйн эмгэг судлалын эмч/лабораторийн эмч, био-анагаахын мэргэжилтэн болон эмнэлгийн тусгай мэргэжилтэн (лаборант/лабораторийн техникч)-ийн харьцаа **1:3-аас** багагүй байна.

А2 Үйл ажиллагааны онцлогоос хамаарч эмнэлгийн үндсэн үйл ажиллагааны үйл ажиллагааны чиглэлээр орон тоог А1-р хүснэгтэд зааснаар тогтооно:

А1-р хүснэгт

№	Үйл ажиллагааны чиглэл	Эмнэлгийн мэргэжилтний ангилал	Орон тоо
1	Эрчимт эмчилгээ (насанд хүрэгчид)	эмч	эрчимт эмчилгээний 3 оронд 1
		сувилагч	эрчимт эмчилгээний 2 оронд 1
2	Хүүхдийн эрчимт эмчилгээ	эмч	эрчимт эмчилгээний 2 оронд 1
		сувилагч	эрчимт эмчилгээний 2 оронд 1
3	Нярайн эрчимт эмчилгээ	эмч	эрчимт эмчилгээний 2 оронд 1
		сувилагч	эрчимт эмчилгээний 2 оронд 1
4	Яаралтай тусламж (насанд хүрэгчид)	эмч	яаралтай тусламжийн хэсэгт 4
		сувилагч	яаралтай тусламжийн хэсэгт 2 оронд – 1
5	Хүүхдийн яаралтай тусламж	эмч	хүүхдийн яаралтай тусламжийн хэсэгт 4
		сувилагч	хүүхдийн яаралтай тусламжийн хэсэгт 4 оронд 1
6	Эх барихын яаралтай тусламж	эмч	эх барихын яаралтай тусламжийн хэсэгт 2
		эх баригч	эх барихын яаралтай тусламжийн хэсэгт 4 оронд 1
7	Эх барих, эмэгтэйчүүд (төрөх тасаг)	эмч	эх барихын 2 оронд 1
		эх баригч	эх барихын 4 оронд 1
8	Эх барих, эмэгтэйчүүд	эмч	эх барихын 8 оронд 1

¹Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.5-д зааснаар

²Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.20-д зааснаар

³Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар

АЗ Үйл ажил лагаа ны онцлог ойуял дуула н А1- р хүснэгтэд зааснаас бусад чиглэлээр үзүүлэх		(төрөхийн өмнөх, төрсний дараахь тасаг)	эх баригч	эх барихын 8 оронд 1
	9	Эх барих, эмэгтэйчүүд (эмэгтэйчүүдийн тасаг)	эмч сувилагч	эмэгтэйчүүдийн 10 оронд 1 эмэгтэйчүүдийн 10 оронд 1
	10	Хүүхэд	эмч сувилагч	хүүхдийн эмчилгээний 8 оронд 1 хүүхдийн эмчилгээний 8 оронд 1
	11	Нярай	эмч	эх барихын 5 оронд 1
				эрүүл нярайн 8 оронд 1
		Нярай	сувилагч	эмгэг нярайн 7 оронд 1
				эх барихын 4 оронд 1
	12	Мэдээгүйжүүлэг	эмч	эрүүл нярайн 8 оронд 1
				эмгэг нярайн 7 оронд 1
			сувилагч	хагалгааны 1 өрөөнд 1
				төрөх тасагт 1
	13	Мэс засал	сувилагч	сэрээх өрөөний 3 оронд 1 хагалгааны 1 өрөөнд 1 сэрээх өрөөний 2 оронд 1
	14	Сүрьеэ (тасаг)	эмч	Хагалгааны 1 оронд 2 сувилагч
	сувилагч		6-7 оронд 1 4	
	15	Сүрьеэ (диспансер)	эмч	50 өвчтөн (5 жилийн дундаж) тутамд 1
			сувилагч	50 өвчтөн (5 жилийн дундаж) тутамд 1-2
			тархвар судлаач	1
	16	Эмнэл зүйн цус сэлбэлт	эрүүл мэндийн нийгмийн ажилтан	1
			эмч	1
	17	Анатомын эмгэг судлалын үйл ажиллагаа	сувилагч	2
эмч/эс судлаач			1	
18	Эмнэл зүйн хоол эмчилгээ	техникч/туслах ажилтан	1	
19	Эмнэлзүйн эм судлалын үйл ажиллагаа	эмч	1 (200 эмч, сувилагчид)	
20	Эмнэлзүйн хор судлал	эмч	0,5-1	

амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хэрэгцээ, ачаалал, эрүүл мэндийн технологи, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн зааварт үндэслэн шаардлагатай эмнэлгийн мэргэжилтэн, бусад ажиллагсдын тоог тооцож, үндсэн орон тоог зохистой бүрдүүлж ажиллана.

А4 Ээлжинд ажиллах эмнэлгийн мэргэжилтнийг эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэвийн байдлыг хангах түвшинд хэрэгцээт тоогоор ажиллуулна.

А5 Ажилтны ажлын ачааллыг харгалзан зөвхөн хэрэгцээ шаардлагатай тохиолдолд мэргэшлийн өндөр ур чадвартай эмнэлгийн мэргэжилтнийг Хөдөлмөрийн тухай хууль бусад холбогдох хууль эрх зүйн хүрээнд байгууллагатай нь гэрээ байгуулан ажиллуулж болно. Эмнэлгийн мэргэжилтэн, эмнэлгийн бусад мэргэжилтний үндсэн болон гэрээгээр нэмэлтээр ажиллуулах ажилтны харьцаа **90-95% : 10- 5%** байна.

A6 Энэхүү стандартад заасан эмнэлгийн үндсэн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагаатай холбоотой дор дурдсан чиглэлээр ажиллах үндсэн ажилтны орон тоог А2-р хүснэгтэд зааснаар тогтооно:

А2-р хүснэгт

№	Үйл ажиллагааны чиглэл	Доод орон тоо
1.	Эдийн засгийн төлөвлөлт, эрүүл мэндийн даатгал, санхүү, нягтлан бодох үйл ажиллагаа	4
2.	Тусламж, үйлчилгээний дотоод хяналт (эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, дотоод халдварын хяналт, дотоод аудитын үйл ажиллагаа)	3
3.	Хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагаа	150 ажилтанд-1
4.	Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн үйл ажиллагаа (статистик мэдээлэл)	3
5.	Сувилахуйн үйл ажиллагааны удирдлага ⁴	2
6.	Нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа	2
7.	Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ ⁵	2
8.	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа (инженер:техникч)	4:2
9.	Мэдээллийн технологийн үйл ажиллагаа	2
10.	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаа	1
11.	Бичиг хэрэг, архивын үйл ажиллагаа	2
12.	Эмнэлгийн аюултай хог хаягдлын менежмент	1
13.	“Эмийн санд тавих нийтлэг шаардлага” стандартын дагуу хүний нөөцийг тооцно.	

A7 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтныг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу ажиллуулна.

